

4. Хүүхдийн тоглоомын талбай

Явган замын хавтанг угсрахдаа элс цементэн багсармал дээр дэвсэж, хавтан хоорондох зайг мөн багсармалаар гагнаж, суларч хонхойхооргүй сайтар бөхлөх шаардлагатай. Чийрэгжүүлэх дасгалын төхөөрөмж, хүүхдийн тоглоом, турник зэргийг суурилуулахдаа 60-80 см-ын гүнд БМ100 маркийн бетон цутгаж хөдөлгөөнгүй, угзралтанд тэсвэртэйгээр байршуулахыг анхаар.

5. Хүүхдийн тоглоомын талбайд төмөр хайс, турник угсрах

Тоглоомын талбайг 60 см-ын өндөртэй төмөр сараалжин хайсаар хашаалах бөгөөд газрын хэвгийнээс хамаараад талбай борооны усанд автахаар бол зураг төсөвт тусгагдсан шон суурийн оронд хашааг шугаман сууринд бэхэлж өгөх нь зүйтэй.

Төмөр хашааг өнгөний шийдэл гарган олон өнгийн будгаар алаглуулж будах эсвэл зураглал хэлбэрээр 2 үе тосон будгаар будна.

6. Гэрэлтүүлгийн ажил

Цахилгаан монтажийн угсралтын ажлыг гүйцэтгэх үед БНБД 3.05.06-90-г мөрдлөг болгоно.

Тоглоомын талбайд 6 метрийн өндөртэй 1 толгойтой 6 ширхэг 100В-ийн лед гэрэлтүүлгийг угсарч, гэрэлтүүлгийн шонг зурагт заагдсан хэмжээтэй сууринд анкерлаж сайтар бөхлөх, Суурийг БМ150 маркийн бетоноор цутгаж хийнэ. Мөн цагийн реле, электрон тоолуур зэргийг угсарч байрлуулна.

7. Сүүдрэвч

Сүүдрэвч хийх модон эдлэлүүдийг сайтар харуулдаж, зүлгүүрээр өнгөлсний дараа 2 үе тосон будгаар будна. Сүүдрэвчний дээврийг OSB хавтангаар хийх ба хавтангийн дээд талд шинглас хар цаас нааж, доод талыг ус чийгнээс хамгаалж 2 үе тосон будгаар будна.

8. Талбай дасгалын төхөөрөмж, тоглоом суурилуулах

Сагсан бөмбөгийн талбай нь 2 талдаа шийдтэй стандарт хэмжээ бүхий талбай байх бөгөөд тухайн баг хорооны иргэд болон зохион байгуулалттай тоглолт хийхэд тохиромжтойгоор шүүгч, тоглогчид, үзэгчид суух талбайд сандал байрлуулна. Төсөвт өгөгдсөн тоо хэмжээний дагуу тоног төхөөрөмж, тоглоомуудыг төслийн байранд байршуулна. Дасгалын төхөөрөмж, гулсуур, савлуур зэргийг худалдан авахдаа найдвартай, бат бөх, төмөр сайтайг нь сонгох нь зүйтэй.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Тохижилтын ажлыг зураг төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсал мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.